



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 2/101

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Төрийн үйлчилгээний салбар байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих 2 ширхэг автобус нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Ш.Нохойжав

- Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Б.Түмэнжаргал

- Орон нутгийн өмчийн газрын Өмчийн мэргэжилтэн

Д.Нямжаргал

- Төрийн бус байгууллагын төлөөлөл

Ж.Ганболд

- Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Х.Дэмид

- Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ш.Нохойжав/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД



02-00436
B/Tush-A/101-Da